



МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМ

19 99 оны 9 сарын 21

№ 6/776

Улаанбаатар хот
Утас: 323273

"CREME DE LA CREME" КОМПАНИЙ ДЭД ЗАХИРАЛ АЛАН ПАРРОТ ТАНАА

Таны тавьсан
хүсэлтийн хариу

Идлэг шонхор шувуу (Falco cherrug)-г барьж экспортод гаргах тухай Таны хүсэлтийг хүлээн авч дараахь хариуг өгч байна.

Бизнесийн зориулалтаар шонхор барих, гадаад улсад гаргах явдлыг Байгаль орчны яамнаас 1998 оноос эхлэн түр зогсоогоод байгаа билээ.

Харин энэ жилийн хувьд бол Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн хоёр орны хоорондын найрамдал, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чин сэтгэлийн илэрхийлэл болгон Арабын Нэгдсэн Эмирт улсын үе залгамжилсан Хунтайж, АНЭУ-ын Зэвсэгт хүчний дэд командлагч, Эрхэм дээд Шейх Халифа бин Зайд аль-Нахьян, Кувейт улсын Эрхэм дээд Шейх Жабар аль-Ахмед аль-Сабах нарт тэдний хүсэлтийн дагуу тус бүр 40 хүртэл тооны идлэг шонхор (Falco cherrug) шувууг бариулахаар шийдвэрлээд байна. АНЭУ, Кувейт улсын дээр дурьдсан Шейхүүдийн бие төлөөлөгч нарт идлэг шонхор шувуудыг барьж Монгол улсын хилээр авч гарах зөвшөөрлийг Байгаль орчны яамнаас олгож байгаагаас биш тэдэнд худалдаж байгаа хэрэг биш.

Иймд зөвхөн төлбөр, хураамжийг нь төлөөд идлэг шонхор шувууг барьж экспортод гаргах тухай таны саналыг хүлээн авах боломжгүй юм.

Харин таны санал болгодог, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчилдаг үнийн хамгийн доод хэмжээ буюу нэг идлэг шонхор шувууны үнэд 20.0 мянган ам.долларыг (төлбөр, хураамжаас гадна) төлөх тохиолдолд таны хүсэлтийг онцгойлон авч үзэж болох юм.



Mend Saikhan

С.МЭНДСАЙХАН